



Улаанбаатар хотоос хонгог түтүмүн хэвлэл  
1 онь 12 дугаар сорын 17  
№47 /716/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

1987

**Онцгой албан татварын тухай  
хуульд өөрчлөлт оруулах  
тухай**

Монгол Улсын  
хууль

1989

**Монгол Улсын Үндсэн хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
журмын тухай хуулийг дагаж  
мөрдөх журмын тухай**

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

2014

**Газрын тос боловсруулах  
үйлдвэр байгуулах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |      |
|------|--|------|
| 438. | Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 1987 |
| 439. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                | 1987 |
| 440. | Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай                                | 1988 |
| 441. | Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1989 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |                   |
|------|---|-------------------|
| 442. | “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай                      | Дугаар 48<br>1989 |
| 443. | “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын хавсралтын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 49<br>1990 |
| 444. | Хуулийн төсөл буцаах тухай  | Дугаар 50<br>1990 |
| 445. | Хуулийн төсөл буцаах тухай  | Дугаар 51<br>1991 |
| 446. | Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай   | Дугаар 53<br>1991 |
| 447. | Шүүгчийн болон прокурорын албан   |                   |



	тушаалын цалингийн хэмжээг шингэлэн тогтоох тухай	Дугаар 54	1992
448.	Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шингэлэн тогтоох тухай	Дугаар 55	1997
449.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 56	1999

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

450.	Зэрэг дэв олгох тухай	Дугаар 225	1999
451.	Зэрэг дэв олгох тухай	Дугаар 226	2000
452.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 230	2000

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

453.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 272	2001
454.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 274	2001
455.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 277	2002
456.	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах тухай	Дугаар 294	2014
457.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 296	2015
458.	Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай	Дугаар 298	2015
459.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 299	2015

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.3.Энэ хуулийн 4.1.4-т заасан суудлын автомашин импортолсон бол үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан дараахь хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж (см³)	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /ам. долларт шилжүүлснээр/ үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа /жилээр/			
		0-3 жил	4-6 жил	7-9 жил	10 ба түүнээс дээш жил
		1	1500 ба түүнээс доош	500	1000
2	1501-2500	1500	2000	3000	7000
3	2501-3500	2000	2500	4000	8000
4	3501-4500	4500	5000	6500	10500
5	4501 ба түүнээс дээш	7000	7500	9000	13000

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэх заалтад дор дурдсан агуулгатай дэд заалт нэмсүгэй:



"д/Монгол Улсаас эх үүсвэртэйгээр шууд болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлого."

**2 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын "Засгийн газрын" гэсний дараа "болон Монгол Улсын Хөгжлийн банкны" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4.2 дахь заалтын "Монгол Улсад орлого олж байгаа" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон" гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "Монгол Улсын нутаг дэвсгэрт болон" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого," гэж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж олсон орлогод" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлогод" гэж, 17 дугаар зүйлийн 17.2.9 дэх заалтын "албан татвар төлөгч Монгол Улсад олсон" гэснийг "албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9.6 дэд заалтын "зээлийн" гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын "Засгийн газрын" гэсний дараа "болон Монгол Улсын Хөгжлийн банкны" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2011 оны 11 дүгээр  
сарын 30-ны өдөрУлаанбаатар  
хот**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.6 дахь заалт, 11.4, 11.5 дахь хэсгийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2011 оны 11 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот**"Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах,  
өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах  
тухай" тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн 5.2 дахь заалтын "үндэсний хөрөнгө оруулагчийг" гэснийг "үндэсний хөрөнгө оруулагчийн оролцоотой хөрөнгө оруулагчийг" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

**“Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах,  
өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах  
тухай” тогтоолын хавсралтын зарим заалтыг  
хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 5.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд 2012 онд Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийн хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

1/иргэн бүрд 128 000 /нэг зуун хорин найман мянган/ төгрөг;

2/55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй ахмад настан бүрд 1 000 000 /нэг сая/ төгрөг;

3/хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрд 1 000 000 /нэг сая/ төгрөг.





2.Энэ тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад заасан хишиг, хувийг 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сар бүр 21 000 /хорин нэгэн мянган/ төгрөгөөр, 2012 оны 6 дугаар сард 23 000 /хорин гурван мянган/ төгрөгөөр бэлнээр, иргэд өөрсдийн санаачилгаар ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтын зорилгоор авах тохиолдолд бэлэн бусаар Засгийн газраас тогтоосон журмын дагуу нэг удаа бөөн дүнгээр нь тус тус тооцож олгосугай.

3.Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийг олгохдоо улсын эдийн засагт аливаа сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тооцож, зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### **Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 1, 2 дугаар хавсралтаар, Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоол, “Шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай” 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 77 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолын 1, 3 дугаар хавсралтыг 2012 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл, 2, 4 дүгээр



хавсралтыг 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
54 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН  
ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	786789.2
2	Нийслэлийн шүүхийн шүүгч	729490.4
3	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	758056.6
4	Аймгийн шүүхийн шүүгч	708609.8
5	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	716460.5
6	Дүүргийн шүүхийн шүүгч	687227.4
7	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	716460.5
8	Сум, сум дундын шүүхийн шүүгч	687227.4
9	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	796789.0
10	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	739490.0

Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН  
ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	967750.7



2	Нийслэлийн шүүхийн шүүгч	897273.2
3	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	932409.6
4	Аймгийн шүүхийн шүүгч	871590.1
5	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	881246.4
6	Дүүргийн шүүхийн шүүгч	845289.7
7	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	881246.4
8	Сум, сум дундын шүүхийн шүүгч	845289.7
9	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	980050.0
10	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	909572.7

Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН  
ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор	777934.9
2	Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	722140.2

3	Нийслэлийн прокурор	774761.6
4	Нийслэлийн прокурорын орлогч	725815.3
5	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	678874.9
6	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	668350.1
7	Аймаг, тээврийн прокурор	746529.5
8	Аймаг, тээврийн прокурорын орлогч	698586.8
9	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	678874.9
10	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	668350.1
11	Дүүргийн прокурор	690902.5
12	Дүүргийн прокурорын орлогч	678874.9
13	Дүүргийн прокурорын газрын туслах прокурор	668350.1
14	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	662670.4
15	Сум, сум дундын ахлах прокурор	690902.5
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	662670.4



Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
54 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН  
ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор	956859.9
2	Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	888232.4
3	Нийслэлийн прокурор	952956.8
4	Нийслэлийн прокурорын орлогч	892752.8
5	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	835016.1
6	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	822070.6
7	Аймаг, тээврийн прокурор	918231.3
8	Аймаг, тээврийн прокурорын орлогч	859261.8
9	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	835016.1
10	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	822070.6
11	Дүүргийн прокурор	849810.1
12	Дүүргийн прокурорын орлогч	835016.1



13	Дүүргийн прокурорын газрын туслах прокурор	822070.6
14	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	815084.6
15	Сум, сум дундын ахлах прокурор	849810.1
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	815084.6

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг 1, 2 дугаар хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтыг 2012 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл, 2 дугаар хавсралтыг 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
55 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН  
ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН  
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Авлигатай тэмцэх газрын дарга	1146694.0
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	1068185.9
3	Хэлтсийн дарга	1024034.0
4	Албаны дарга	970089.2
5	Ахлах ажилтан	889172.0
6	Ажилтан	808254.8

Монгол Улсын Их Хурлын 2011 оны  
55 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН  
ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН  
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Авлигатай тэмцэх газрын дарга	1410433.6
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	1313868.7
3	Хэлтсийн дарга	1259561.8
4	Албаны дарга	1193209.7
5	Ахлах ажилтан	1093681.6
6	Ажилтан	994153.4

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот**Тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай жуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2012 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн "Цалингийн жэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар  
хот**Зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүгчид зэрэг дэв олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрахад "Тэргүүн түшээ" зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар  
хот

### Зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан "Үндэсний статистикийн газрын дарга, дэд даргын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн саналыг үндэслэн Үндэсний статистикийн хорооны дэд дарга Б.Эрдэнэсүрэнд "Дэд түшээ" зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 12 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар  
хот

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан тул Тайванхүүгийн Баасанжаргалыг Завхан аймаг дахь сум дундын хоёрдугаар шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Төмөрийн Баясгаланг Дорноговь аймаг дахь сум дундын нэгдүгээр шүүхийн шүүгчийн, Сэрээнэнгийн Оюунцэцэгийг Орхон аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 9 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 272

Улаанбаатар  
хот**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2011 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Украин Улсын Киев хотод гарын үсэг зурсан "Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын сайд нарын Танхим хоорондын хэлэлцээрийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД****М.ЭНХБОЛД****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 9 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 274

Улаанбаатар  
хот**Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 221 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам"-ын 3.6-д "шаардагдах мөнгөн дүнд вексель бичиж" гэснийг "мөнгөн дүн бүхий албан бичгийг зээл олгох шийдвэрийн хамт" гэж, 3.7-д "...гаргасан векселийг" гэснийг "...ирүүлсэн албан бичиг, зээл олгох шийдвэрийг" гэж, 3.9-д "Векселийн" гэснийг "Зээлийн" гэж тус тус өөрчилсүгэй.



2 .Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ноолуурын үйлдвэр, арилжааны банкуудыг мэдээллээр шуурхай ханган хамтран ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 9 дүгээр  
сарын 21-ний өдөр

Дугаар 277

Улаанбаатар  
хот

### **Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг нь зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд даалгасугай.

3. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтын 8 дахь заалтад "Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс" гэснийг "Монголын амьтан, ургамал хамгаалах үндэсний хороо" гэж өөрчилсүгэй.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, Монголын амьтан, ургамал хамгаалах үндэсний хорооны нарийн бичгийн даргын цалингийн сан болон үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад

тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

5. Цөөвөр чоно, соргог бөхөнг сэргээн өсгөх боломжийг тогтоох, арга технологийг боловсруулах чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 269 дүгээр тогтоол, “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2003 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 121 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

Засгийн газрын 2011 оны 277 дугаар  
тогтоолын хавсралт

**НЭН ХОВОР, ХОВОР АМЬТДЫГ ХАМГААЛАХ  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Манай улсын амьтны аймаг 138 зүйлийн хөхтөн, 75 зүйлийн загас, 22 зүйлийн мөлхөгч, 6 зүйлийн хоёр нутагтан, 472 зүйлийн шувуу, 13000 гаруй зүйлийн шавьж, 516 зүйлийн зөөлөн биетэн, эгэл биетнээс бүрддэг.

Сүүлийн жилийн судалгаагаар 20 гаруй толгой мазаалай, 6.0 мянга гаруй толгой хүдэр, 350 орчим толгой хавтгай, 1000-1200 толгой цоохор ирвэс, 300 гаруй толгой төв азийн минж, 17.9 мянган толгой аргаль хонь, 24.4 мянган толгой янгир ямаа, 16.0 мянга гаруй толгой халиун буга, 7.0 мянга гаруй толгой шивэр хандгай, 12.0 мянга гаруй толгой хар сүүлтий, 8.0 мянга орчим толгой монгол бөхөн, 250 орчим толгой хүрэн баавгай, 6.0 мянга орчим идлэг шонхор шувуу байна. Шивэр хандгай, хар мөрний хандгай, хүдэр, зэгсний гахай, голын халиу, цоохондой мий, цаа буга, хар сүүлтий, алтайн хойлог зэрэг ихэнх нэн ховор, ховор амьтдын нөөц, тархацын сүүлийн үеийн судалгааны нэгдсэн мэдээ баримт байхгүй байна.



Нэн ховор, ховор амьтдын байршил нутгийг хамгаалахад түлхүү анхаарч ажилласны үр дүнд үндэсний хэмжээнд төдийгүй дэлхийд нэн ховордсон хавтгай, мазаалай, монгол бөхөн, шивэр хандгай, шилүүс мий, зэгсний гахай, тахь зэрэг амьтдын тархац нутгийг бүрэн хэмжээгээр, цоохор ирвэс, хулан, хүдэр, аргаль хонь, янгир ямаа, голын халиу зэрэг амьтдын тархац нутгийн 70 орчим хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулаад байна. Үүний зэрэгцээ халиун буга, хүдэр, аргаль хонь, янгир ямаа, хар сүүлтний зэрэг амьтдыг зориудаар өсгөн үржүүлэх туршилт, судалгааны ажил хийж, уугуул нутагтаа устаж үгүй болсон тахийг байгальд нь сэргээн нутагшуулсны үр дүнд тэдгээрийн тоо толгой 400 орчим болжээ.

Хулан, монгол бөхөн, цоохор ирвэс зэрэг нэн ховор амьтдын хууль бус агналт саарч, тэдгээрийн тоо толгой нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай орны уур амьсгал дулаарах, хур тунадасны хэмжээ багасах, жигд бус хуваарилагдах, ой хээрийн түймэр, түүний учруулах хохирлын хэмжээ ихсэх, цөлжилт эрчимжих, булаг, шанд, гол, горхи, нуур, цөөрөм ширгэх, ган, зуд, хүчтэй цасан ба шороон шуурганы тоо нэмэгдэх зэрэг байгалийн хүчин зүйлээс амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл эрчимжиж байна.

Амьтдыг хамгаалах менежмент боловсронгуй бус, санхүүжилтийн тогтвортой механизм бүрдээгүй, боловсон хүчний хангамж дутагдалтай, байгаль орчны хяналтын нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, уул уурхай, газрын тос, дэд бүтцийн томоохон төслийг хэрэгжүүлэхдээ амьтны байршил нутгийг эзэгнэх, орчныг бохирдуулан доройтуулах, гар аргаар ашигт малтмал олзворлох зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлсийн нөлөөгөөр ховор амьтны нөөц хомсдож, тархац нутаг нь хумигдаж байна. Тухайлбал, соргог бөхөн, цөөвөр чоно бүрэн устсан байх магадлал өндөр байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим,  
хамрах хүрээ

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1.1. нэн ховор, ховор амьтдын тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулж, уугуул нутагт нь хамгаалах, сэргээн нутагшуулах;

2.1.2. мазаалай, хавтгай, монгол бөхөн зэрэг устаж болзошгүй нэн ховор зүйл амьтдын удмын санг хадгалах;

2.1.3. ан амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн холбоод болон төрийн бус мэргэжлийн байгууллага, иргэний нөхөрлөлд тодорхой нөхцөл болзолтой гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх;

2.1.4. ан амьтдыг ашиглагч нь хамгаалдаг байх, төлбөр төлдөг байх.

2.2. Хөтөлбөрийн хамрах хүрээнд Амьтны аймгийн тухай хуулийн 7.1-д заасан нэн ховор амьтан болон мөн хуулийн 7.6-д заасны дагуу Засгийн газраас тогтоосон ховор амьтдаас гадна Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай (CMS) болон Зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцуудын I, II хавсралтад бүртгэгдсэн амьтад тус тус багтана.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлж, байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөлийг нь хангах, зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгой, тархац нутгийг нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх дараахь зорилтыг дэвшүүлж байна:

Нэгдүгээр зорилт. Нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос сэргийлэх, тэдгээрийн хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон эрх зүй, эдийн засгийн тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын түвшинд хүргэх;

Хоёрдугаар зорилт. Нэн ховор, ховор амьтдыг уугуул нутагт нь хамгаалж, байгалийн жамаар өсөж үржих тааламжтай нөхцөлийг хангах зорилгоор тэдгээрийн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, хамгаалалтын менежментийг төгөлдөржүүлэх;

Гуравдугаар зорилт. Дэлхийн болон үндэсний хэмжээнд устах аюулд орсон амьтдыг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах, зориудын орчинд өсгөн үржүүлэх, удмын санг хадгалах замаар тэдгээрийн тоо толгойн тогтвортой өсөлтийг хангах дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, тогтвортой ашиглах;



Дөрөвдүгээр зорилт. Уур амьсгалын дулааралт, байгалийн нөөцийн хомсдол, орчны бохирдлоос нэн ховор, ховор амьтны удмын санг хамгаалах салбар хоорондын зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх;

Тавдугаар зорилт. Нэн ховор, ховор амьтдын талаархи иж бүрэн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрчимжүүлж, шинжлэх ухааны дэвшилтэт ололт, технологийг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, устаж болзошгүй амьтдын талаархи мэдлэг хүмүүжлийг иргэдэд олгох сургалт сурталчилгааг тогтмолжуулах.

3.3. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд:

3.3.1.1. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх эрх зүй, эдийн засгийн орчныг боловсронгуй болгоно;

3.3.1.2. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах зохион байгуулалтын оновчтой бүтцийг бүрдүүлж, орон нутгийн захиргааны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана;

3.3.1.3. нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний, бус нутгийн болон орон нутгийн урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон ан амьтны менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ;

3.3.1.4. ан амьтны менежментийн төлөвлөгөөг үндэслэн нэн ховор, ховор амьтны байршил нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн орон нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагад хариуцуулан хамгаалах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлж, хэрэгжүүлнэ;

3.3.1.5. орчин үеийн шаардлага, эрэлт хэрэгцээг тодорхойлох замаар боловсон хүчин бэлтгэх, чадавхижуулах сургалтын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтмол жигд явуулах нөхцөлийг бүрдүүлнэ;

3.3.1.6. нэн ховор, ховор амьтны хууль бус агнуур, худалдааг таслан зогсоох хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, материаллаг бааз, боловсон хүчнээр хангана.

3.3.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

3.3.2.1. нэн ховор, ховор амьтдын үндсэн тархац



нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд бүрэн хамруулж, хамгаалалтыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн сайжруулна;

3.3.2.2. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд нэн ховор, ховор амьтны зүйл бүрийг хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг үе шаттайгаар тусган хэрэгжүүлнэ;

3.3.2.3. нэн ховор, ховор амьтны тархац нутгийг олон улсын шим мандлын нөөц газрын, дэлхийн өвийн сүлжээ болон олон улсын гэрээнд хамруулж, тэдгээрийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг хандивлагч орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх ажлын цар хүрээг өргөтгөн, үр дүнг сайжруулна;

3.3.2.4. ОХУ, БНХАУ зэрэг орнуудтай хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж, хил орчмын нэн ховор, ховор амьтдыг хамгаалан хил дамнан тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, хамгаалалтын менежментийг сайжруулна;

3.3.2.5. нэн ховор, ховор шувуу, загас, мэлхий, эрвээхэй, хавч, хясааны тархац нутгийг олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн хавсралт болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулан хамгаална.

### 3.3.3. Гуравдугаар зорилтын хүрээнд:

3.3.3.1. халиун буга, цаа буга, хүдэр, мазаалай, хавтгай, монгол бөхөн зэрэг нэн ховор, ховор амьтдыг уугуул нутагт нь зориудын орчинд өсгөн үржүүлж, тоо толгойг нэмэгдүүлнэ;

3.3.3.2. аргаль хонь, янгир ямаа, хар сүүлтий, зэгсний гахай, монгол бөхөн, халиун буга, хүдэр, хулан, тахь, голын халиу болон тул, шивэр хилим, хар мөрний хилим зэрэг нэн ховор, ховор амьтдыг уугуул нутагт нь сэргээн нутагшуулна;

3.3.3.3. устах аюулд орсон мазаалай, хавтгай, монгол бөхөн, голын халиу, зэгсний гахай, шивэр хандгай, хар мөрний хандгай, цаа буга зэрэг амьтдын удмын санг хадгалж, биотехнологийн орчин үеийн дэвшилтэт аргаар өсгөн үржүүлнэ;

3.3.3.4. ховор амьтдын агнуур зохион байгуулалт явуулах, агнуурын амьтдын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулна;





3.3.3.5. агнуурын ач холбогдол бүхий халиун буга, хүдэр, монгол бөхөн, зэгсний гахай зэрэг амьтдын үржүүлгийн төв байгуулж, тэдгээрийн тоо толгойг нэмэгдүүлэх замаар бугын эвэр, хүдрийн заарыг олзворлож, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн гаргана;

3.3.3.6. аргаль хонь, янгир ямаа, хар сүүлтий, халиун буга зэрэг ховор амьтдыг сэргээн нутагшуулах, тогтвортой өсгөн үржүүлэх замаар агнуурын бүс нутаг байгуулж, тусгай зориулалтаар тогтвортой ашиглах агнуурын нөөцийг нэмэгдүүлнэ;

3.3.3.7. нэн ховор, ховор зарим амьтдын экологи-эдийн засгийн үнэ цэнийг тогтоож, тэдгээрийн идээшил нутгийг түшиглэсэн амьтны хүрээлэнг хангай, цөлийн бүсэд байгуулах угтвар нөхцөлийг бүрдүүлж, гадаадын жуулчид, амьтан судлаачдын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

3.3.3.8. идлэг шонхор шувууг хууль бусаар ашиглахыг зогсоох зорилгоор хамгаалалтыг сайжруулсны үндсэн дээр тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

### 3.3.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

3.3.4.1. нэн ховор, ховор амьтдын байршил нутгийн булаг шанд, гол, горхи, нуур, цөөрөм уур амьсгалын дулааралтаас үүдэн ширгэхээс урьдчилан сэргийлж, ширгэсэн уст цэгийг нөхөн сэргээж, цас, борооны усыг хуримтлуулан усан сан, цөөрөм байгуулна;

3.3.4.2. нэн ховор, ховор амьтдын үндсэн тархац нутгийн түймэрт шатсан ой, ургамлыг нөхөн сэргээж, түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд шуурхай унтраах, амьтан, ургамал, ойн санд учирсан хохирлыг үе шаттайгаар арилгана;

3.3.4.3. ган, зудын гамшиг тохиолдсон үед нэн ховор, ховор амьтдыг авран хамгаалах, тэдгээрт өвс тэжээл, хужир шүү тавих зэрэг биотехникийн арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусгаж, тэдгээрийн тоо толгойг хомсдохоос сэргийлнэ;

3.3.4.4. томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад нэн ховор, ховор амьтдын тархац нутаг хумигдах, нүүдлийн зам хаагдах, тоо толгой цөөрөх, амьдрах орчин доройтохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг уг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбарын эрхэлсэн сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлнэ;

3.3.4.5. нэн ховор, ховор амьтдын байршил нутагт хүн,

мал, амьтны халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, өвчин гарсан тохиолдолд өвчний голомтыг арилгах, түүний хор хөнөөлийг бууруулах арга хэмжээг мал эмнэлэг, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, өвчний оношилгоо, тархалтын судалгаа явуулах шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудаас дэмжлэг туслалцаа авна;

3.3.4.6. нэн ховор, ховор амьтдын байршил нутгийн ус, бэлчээрийн талхагдлыг хязгаарлан зогсоож, нөхөн сэргээж, амьтны нөөц бэлчээр бий болгоно;

3.3.4.7. нэн ховор, ховор амьтны биоаюулгүй байдлыг хангана.

### 3.3.5. Тавдугаар зорилтын хүрээнд:

3.3.5.1. нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийн нөөц, тархац, экологи, биологи, генетикийн иж бүрэн судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлнэ;

3.3.5.2. тахь, хавтгай, мазаалай, монгол бөхөн, цоохор ирвэс зэрэг нэн ховор амьтдыг олон улсын байгууллага, гадаадын зарим орны хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “загвар” хэмжээнд судалж, тэдгээрийн ажлын ололт, туршлагыг устах аюулд ороод байгаа бусад зүйл амьтдад туршин нэвтрүүлнэ;

3.3.5.3. нэн ховор, ховор амьтдын үндсэн байршил нутгийн байгаль, цаг уурын хувьсал өөрчлөлт, байгалийн нөөцийн төлөв байдал, орчны бохирдлыг тандан судлах ажлыг ус, цаг уур, орчны шинжилгээний хяналт, шинжилгээний нэгдсэн сүлжээнд хамруулна;

3.3.5.4. мазаалай, хавтгай, хар мөрний хандгай, шивэр хандгай, голын халиу, монгол бөхөн, зэгсний гахай, минж, хүдэр, цаа буга зэрэг устаж болзошгүй нэн ховор амьтдын удмын сангийн лабораторийг байгуулж, биотехнологийн дэвшилтэт аргаар өсгөн үржүүлэх туршилт, судалгаа явуулах ажлын бэлтгэлийг хангана;

3.3.5.5. бүх шатны экологийн сургалтын хөтөлбөрт нэн ховор, ховор амьтдын талаархи мэдлэг боловсролыг иргэдэд олгох асуудлыг тусган, байгаль хамгаалах талын мэдлэг олгох сүлжээ бий болгон ажиллуулна;

3.3.5.6. нэн ховор, ховор амьтдын бүх түвшний менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд нутгийн



иргэдийн төлөөлөл, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ;

3.3.5.7. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэд, тэдгээрийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин урамшуулж олон нийтэд сурталчилна;

3.3.5.8. иргэдэд орон нутгийнхаа амьтдыг хамгаалах, нөөцийг тогтоох уламжлалт арга мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулж, нэн ховор, ховор амьтдын талаар кино, гарын авлага, зурагт хуудсыг гаргаж, нийтийн хүртээл болгохын зэрэгцээ дэлхий дахинд сурталчлах ажлыг зохион байгуулна;

3.3.5.9. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах чиглэлээр үндэсний, бүс нутгийн болон олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг өргөжүүлнэ;

3.3.5.10. Монгол орны "Улаан ном"-д орж байгаа амьтдын ангиллыг Олон улсын байгаль хамгаалах холбооноос (IUCN) гаргасан улаан дансны ангилалтай уялдуулж, мэдээллийг тогтмол шинэчилж байна.

#### Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Монголын амьтан, ургамал хамгаалах үндэсний хороо холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэрэгжилтийг 2 жил тутам Засгийн газарт тайлагнана.

4.2. Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

4.2.1. улсын болон орон нутгийн төсөв;

4.2.2. байгаль хамгаалах сан;

4.2.3. олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;

4.2.4. бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

5.1. Хөтөлбөр 2011-2021 оны хооронд дараахь үе шаттайгаар хэрэгжинэ:

5.1.1. Нэгдүгээр үе шат 2011-2016 он;

5.1.2. Хоёрдугаар үе шат 2017-2021 он.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат: 2011-2016 он

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

6.1. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ;

6.2. нэн ховор, ховор амьтдын менежментийг эрхлэх удирдлага, зохион байгуулалтын бүтэц шинээр бий болно;

6.3. нэн ховор, ховор амьтдын тархац нутгийг нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн төрийн бус байгууллагад хариуцуулан хамгаалж эзэмшүүлснээр амьтны нөөцийг өсгөн арвижуулах сонирхлын механизм бүрдэнэ;

6.4. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, чадавхижуулах тогтолцоо боловсронгуй болно;

6.5. нэн ховор, ховор амьтдын хууль бус агналт, худалдааг хязгаарлан зогсооно;

6.6. гадаад хамтын ажиллагаа өргөжиж, төсөл, хөтөлбөрүүд шинээр хэрэгжинэ.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

6.7. устаж болзошгүй нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийн үндсэн тархац нутгийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад бүрэн хамруулж, хамгаалалтын менежментийг шинэчилснээр тэдгээрийн хамгаалалт



сайжирч, байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөл бүрдэнэ.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

6.8. хүдэр, мазаалай, хавтгай, монгол бөхөн, халиун буга, цаа буга, зэгсний гахай зэрэг нэн ховор амьтдыг зориудаар өсгөн үржүүлж, аргаль, янгир, хар сүүлтий, зэгсний гахай, хүдэр, монгол бөхөн, тахь, голын халиу, шивэр хилим, хар мөрний хилим зэрэг амьтдыг уугуул нутагт нь сэргээн нутагшуулснаар тэдгээрийн тархац нутаг өргөжиж, тоо толгой нэмэгдэнэ.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

6.9. нэн ховор, ховор амьтдын экологи-эдийн засгийн үнэлгээ баталгаажиж, халиун буга, аргаль хонь, янгир ямаа, хар сүүлтий, идлэг шонхор зэрэг ховор амьтдыг тусгай зориулалтаар тогтвортой ашиглах нөхцөл бүрдэнэ;

6.10. иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага нь агнуурын ач холбогдол бүхий халиун буга, хүдэр, монгол бөхөн зэрэг амьтдыг уугуул нутагт нь зориудын орчинд өсгөн үржүүлэх ажлын эхлэл тавигдана;

6.11. агнуурын нөөц газар бий болж, говь, цөлийн бүсэд нэн ховор, ховор амьтдын амьтны хүрээлэн байгуулах ажлын эхлэл тавигдаж, байгалийн аялал жуулчлалын цар хүрээ өргөжинө;

6.12. уур амьсгалын дулааралт, байгалийн гэмшиг, халдварт өвчин, орчны бохирдол, доройтол, бэлчээрийн талхагдлаас нэн ховор, ховор амьтдыг хамгаалах ажилд бодитой ахиц гарна.

Тавдугаар зорилтын хүрээнд:

6.13. нэн ховор, ховор амьтдын зүйл бүрийн нөөц, тархац, биологи, экологи, генетикийн судалгаа хийгдэж, тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх шинжлэх ухааны үндэслэл тодорхойлогдоно;

6.14. нэн ховор, ховор зарим амьтдыг зориудын орчинд өсгөн үржүүлэх, уугуул нутагт нь сэргээн нутагшуулах арга технологи нэвтэрнэ;

6.15. нэн ховор, ховор амьтдын байршил нутгийн байгаль орчны төлөв байдлыг судлах хяналт, шинжилгээний төв, амьтны удмын сангийн лаборатори байгуулагдана;

6.16. нэн ховор, ховор амьтны талаархи мэдлэг боловсрол дээшилж, сурталчилгааны ажил тогтмолжиж, иргэдийн оролцоо, идэвх санаачилга сайжирна.

Хөтөлбөрийн хоёрдугаар үе шат: 2017-2021 он

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

6.17. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах эрх зүй, эдийн засгийн тааламжтай орчин бүрдэж, удирдлага, зохион байгуулалт дэлхийн жишигт хүрнэ;

6.18. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах хяналтын нэгдсэн тогтолцоо төлөвшиж, хууль бус агналт, худалдааг таслан зогсооно.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

6.19. нэн ховор, ховор амьтдын үндсэн тархац нутаг тусгай хамгаалалтад бүрэн хамрагдаж, менежмент олон улсын жишигт хүрснээр тоо толгой нэмэгдэж, тархац нутгийн хэмжээ өргөжинө.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

6.20. халиун буга, аргаль хонь, янгир ямаа, монгол бөхөн, хар сүүлтий зэрэг амьтдын агнуурын тогтвортой нөөц бүрдэнэ.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

6.21. халиун буга, хүдэр, монгол бөхөн, хавтгай, мазаалай, цаа буга, зэгсний гахай зэрэг амьтдын үржлийн туршилт үйлдвэрлэлийн төвүүд байгуулагдаж, ховор зүйл амьтдын ангийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлдөнө.

Тавдугаар зорилтын хүрээнд:

6.22. устаж болзошгүй амьтдын удмын сангийн лаборатори байгуулагдаж, тэдгээрийг орчин үеийн биотехнологийн аргаар өсгөн үржүүлэх нөхцөл бүрдэнэ;

6.23. нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх



чиглэлийн шинжлэх ухааны байгууллагуудын гадаад хамтын ажиллагаа өргөжиж, ажлын үр дүн сайжирна;

6.24. нэн ховор, ховор амьтдын талаархи бүх нийтийн мэдлэг боловсрол дээшилж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо шинэ шатанд гарна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 10 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 294

Улаанбаатар  
хот

### Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн Улсын Их Хурлын 2010 оны 45 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2011 оны 39 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дархан-Уул аймагт жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үндэсний үйлдвэр төсөл"-ийг хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн өмчийн оролцоотой үйлдвэр байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо, судалгааг үргэлжлүүлэн хийж тодотгосны үндсэн дээр үйлдвэрийг үүсгэн байгуулах хэлэлцээр хийж, дүрэм, бүтцийг хууль тогтоомжийн дагуу боловсруулж, батлах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

3. Үйлдвэр байгуулах төслийн санхүүжилтийн зээлд Засгийн газраас баталгаа гаргахгүйгээр өөрийн эзэмших хувь оролцооны хэмжээнд хөрөнгө оруулж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 10 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 296

Улаанбаатар  
хот**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

"Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд "-Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс /хяналт шинжилгээ, үнэлгээний тасагтай/" гэснийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"-Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс;  
-Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг;"

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийг Засаг даргын Тамгын газрын даргын шууд удирдлагад ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 10 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 298

Улаанбаатар  
хот**Улсын төсөвт үйлдвэрийн газар  
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, 22 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Булган аймгийн Хангал суманд байрлах "Спорт бэлтгэлийн төв"-ийг үндэсний шигшээ баг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг хангах үүрэг бүхий "Спортын бэлтгэл, сургалтын төв" улсын төсөвт үйлдвэрийн газар, "Буянт-Ухаа биеийн тамир, спортын





ордон"-г "Буянт-Ухаа Спортын ордон" улсын төсөвт үйлдвэрийн газар болгон тус тус өөрчлөн байгуулсугай.

2. "Буянт-Ухаа Спортын ордон", "Спортын бэлтгэл, сургалтын төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

3. "Буянт-Ухаа Спортын ордон", "Спортын бэлтгэл, сургалтын төв" улсын төсөвт үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны зардлыг төсөвт жил бүр тусган санхүүжүүлж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай" Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 282 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

**С.ЛАМБАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 10 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 299

Улаанбаатар  
хот

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нью-Йорк хотод 2011 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв байгуулах тухай олон талт хэлэлцээрийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**

#### Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.  
Утас 329487